



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/740.

Булган сум

Ажлын хэсэг байгуулж, хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.1.3.1, 1.6.1.1, 1.6.1.6, 1.6.3.1 дэх заалт, 2023 оны XVII дугаар хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” XVII/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/593 дугаар “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг тодотгон батлах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөөгийн хүн амд чиглэсэн төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн суурь үйлчилгээг нэг дороос хурдан шуурхай, чанартай хүргэх зорилгоор “Хүрч үйлчилье” нэгдсэн арга хэмжээг Бугат, Сэлэнгэ суманд зохион байгуулсугай.

2. “Хүрч үйлчилье” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: М.Батчимэг – (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: Н.Батжаргал – (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

Х.Батхишиг – (Биеийн тамир, спортын газрын дарга)

Ц.Энх-Амгалан – (Нийгмийн даатгалын хэлтсийн дарга)

Б.Ариунболд – (Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга)

М.Энхбаяр – (Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн)

У.Мягмарсүрэн – (Нэгдсэн эмнэлгийн дотрын эмч)

Б.Цогтгэрэл – (Нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүдийн эмч)

М.Ариунаа - (Нэгдсэн эмнэлгийн шүдний эмч)

Д.Буянхишиг - (Нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн эмч)

Э.Одмаа – (Нэгдсэн эмнэлгийн дүрс оношлогооны эмч)

Б.Маралгуа - (Нэгдсэн эмнэлгийн эх баригч)

Э.Энхмаа - (Нэгдсэн эмнэлгийн рентген технигч)


Д.Ганганцэцэг - (Нэгдсэн эмнэлгийн лаборант)

Б.Даваадорж – Нэгдсэн эмнэлэг цахим бүртгэл

Нарийн бичгийн дарга: М.Солонго – (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

3. Арга хэмжээний удирдамжийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.
4. Арга хэмжээг чанартай, хурдан шуурхай зохион байгуулж, мэргэжил арга зүй, удирдлагаар ханган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга, Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасугай.
5. “Хүрч үйлчилье” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 3,949,230 (гурван сая есөн зуун дөчин есөн мянга хоёр зуун гуч) төгрөгийг “Эрүүл мэнд” хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

01 Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дугаар сарын
... өдрийн 11 дугаар захирамжийн дүгээр хавсралт

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ “ХҮРЧ ҮЙЛЧИЛБЕ 2023” НЭГДСЭН АРГА
ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ УДИРДАМЖ**

ҮНДЭСЛЭЛ: Манай аймаг 2022 оны жилийн эцсийн байдлаар 62400 гаруй хүн амтай, үүнээс 80 хувь нь хөдөө орон нутагт ажиллаж, амьдарч байна. Хүн амын дийлэнх нь хөдөө тархан суурьшиж байгаа нь нийгмийн суурь үйлчилгээг түргэн шуурхай авах, аймгийн төврүү явах шаардлагатай болох, мэдээлэл авахад хүндрэлтэй байх бэрхшээл байсаар байна.

Хөдөөгийн иргэдэд чиглэсэн төрийн байгууллагуудын үйлчилгээг нэг дороос саадгүй хүргэх зорилгоор 2022 онд “Хүрч үйлчлель” арга хэмжээг Баяннуур, Бугат, Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Орхон, Рашаант, Сайхан суманд зохион байгуулж, нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, шинжилгээ, оношлогоо, Нийгмийн даатгалын үйлчилгээ, зорилтот бүлгийн өрхүүдтэй биечлэн уулзаж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, боловсролын үйлчилгээний хүртээмж, багш, ажилчидын уулзалт, хүн амын бие бялдарын түвшин тогтоох сорилт иргэдийг хамруулах зэрэг арга хэмжээг зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрсэн.

“Хүрч үйлчлель” арга хэмжээг цаашид уламжлал болгон зохион байгуулж, бүх сумдад хүрч ажиллахыг зорьж байна.

ЗОРИЛГО: Хөдөөгийн хүн амд чиглэсэн төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, түүнчлэн нийгмийн суурь үйлчилгээг (эрүүл мэнд, нийгмийн даатгал, халамж, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, биеийн тамир) нэг дороос хурдан, шуурхай хүргэх замаар нийгмийн салбарын байгууллагуудын үйл ажиллагааны давхардал, үр ашиггүй байдлыг багасгахын зэрэгцээ тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулж, хамтын ажиллагааг дэмжих зорилготой.

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ: аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг тус арга хэмжээг удирдан чиглүүлж, нийгмийн салбарын байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулна.

ХАМРАХ ХҮРЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА: Баяннуур, Дашинчилэн сумын баг, өрхийн хэмжээнд үйл ажиллагаа зохион байгуулж, 0-17 насны хүүхэд, 18-34 насны залуучууд, төрийн албан хаагчид, зорилтот өрхийн гишүүд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажилгүй иргэдийг хамруулна.

Сэлэнгэ суманд – 2023 оны 11 дүгээр сарын 08-09 өдөр
Бугат суманд – 2023 оны 11 дүгээр сарын 10-11 өдөр

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

1. Хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ЭМГ-аас тусгай удирдамжийн дагуу дараах чиглэлээр хүргэнэ. Үүнд:
 - Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношлогоог зохион байгуулах
 - Аймгийн Засаг даргын нэрэмжит нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, оношлогоог хийх
 - Хүн амд чиглэсэн эрүүл аж төрөх ёс, дадал хэвшлийн хүрээнд халдварт, халдварт бус өвчнөөс сэргийлэх талаарх мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах

- Сумын эрүүл мэндийн төвүүдэд мэргэжилт арга зүйн зөвлөмжөөр хангах
 - Өсвөр үеийнхэнд чиглэсэн сэтгэл зүйн тулгамдсан асуудлаа шийдвэрлэх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл өгөх
 - Сүрьеэгийн идэвхитэй илрүүлэг үзлэгт зорилтот бүлгийн хүн амыг хамруулах
 - Эмийн зохистой хэрэглээний талаар эмч, эмнэлгийн мэргэжилтэн, иргэдийг хамруулан зохион байгуулах
2. Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр тусгай удирдамжийн дагуу дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:
- Эрүүл мэндийн даатгалд хамрагдах ач холбогдлын талаар иргэдэд мэдээлэл өгөх уулзалтыг сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулах
 - Зорилтот өрхийн гишүүдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах
3. Биеийн тамир спортын чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:
- Хүн амын бие бялдарын түвшин тогтоох сорилд иргэдийг хамруулах
 - Ажлын байранд хийх дасгал хөдөлгөөнийг заах
 - Өдөр бүр дасгал, хөдөлгөөнөөр хичээллэхийн ач холбогдлын талаар иргэдэд мэдээлэл өгөх
4. Хөдөлмөр, нийгэм хамгааллын үйлчилгээний чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:
- Зорилтот 20 өрхөөр зочлон өрхийн гишүүдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулан, нөхцөл байдлын үнэлгээ хийж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх талаар мэдээллээр хангах
 - Хөдөлмөрийн аюулгүй байдлын зөвлөмж, чиглэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах

ХҮРЭХ ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

Сумдын хүн амын нийгмийн үйлчилгээг үзүүлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:

- Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт 0-17 насны хүүхэд, 18-34 насны залуучууд, төрийн албан хаагч, зорилтот өрхийн гишүүдийг хамруулсан байх
- Боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зөвлөмж өгсөн байна.
- Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэдийг сайн дурын даатгалд хамруулсан байх
- Иргэдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 500-аас доошгүй иргэдийг хамруулсан байх
- Хүн амын бие бялдарын түвшинг тогтоож, илүүдэл жинтэй, таргалалттай иргэдэд зөвлөгөө өгөх
- Нийгмийн суурь үйлчилгээний мэдээлэл иргэдэд бүрэн хүрч, нэг дороос үйлчилгээг авах нөхцөл боломж бүрдсэн байх

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна. Үүнд:

- Эрүүл мэнд, нийгмийн даатгал, хөдөлмөр, нийгэм хамгааллын үйлчилгээг нэг дороос үзүүлснээр төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, тэдгээрийн талаарх ойлголт, мэдээлэл, ил тод байдлыг сайжруулах боломжийг бүрдүүлнэ.
- Нийгмийн салбарын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, хамтын ажиллагаа сайжирна.

- Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгээр шинээр оношлогдсон, төрөлжсөн нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээнд зайлшгүй орох шаардлагатай иргэдийг цаг алдалгүй дараагийн шатлалд шилжүүлэх, эмчлэн, эрүүлжүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- Бие бялдарын түвшин тогтоох сорилоор бие бялдарын хөгжлийн түвшин хүрэхгүй насны бүлгийг тодорхойлж, тэдэнд чиглэсэн биеийн тамираар хичээллэх, чийрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон байна.
- Хөдөөгийн хүн ам нийгмийн суурь үйлчилгээний талаарх нэгдсэн ойлголт мэдээлэл авч, цаг алдалгүй хурдан шуурхай үйлчилгээ авах нөхцөл бүрдсэн байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дугаар сарын
01 өдрийн 11 дугаар захирамжийн.... дугаар хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ "ХҮРЧ ҮЙЛЧИЛБЭ" НЭГДСЭН
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт
1.	Шатахууны зардал (4 машин 330 км)	Литр	334	2520	841,680
2	Шатахууны зардал (2 машин 330 км)	Литр	215	4370	939,550
3.	Хүнсний багц (гурил, будаа, тос)	Өрх	40	50000	2,000,000
4	Хулдаасан хэвлэл	М ²	6	19000	114,000
5	Батламж хэвлэл	Ширхэг	5	10800	54,000
	Дүн				3,949,230